



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/201

Дадал сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 11.10 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 05, 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2024 оны А/168 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад ялагч болсон 4 (дөрөв) малчдын хоршоонд хавсралтад заасан газрыг эзэмшүүлсүгэй.

2. Малчдын хоршоонд эзэмшүүлсэн нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж, газар эзэмших эрхийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээг баталгаажуулахыг Газрын даамал (Б.Урансайхан)-д үүрэг болгосугай.

3. Газрыг зориулалтын дагуу ашиглаж, гэрээнд заасан нөхцөл, болзлын хүрээнд газрын төлбөрийг хугацаанд нь төлж байхыг газар эзэмшигч малчдын хоршоонд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000470

Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
А/201 тоот захирамжийн хавсралт

[illegible]